“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК

Хараат бус Аудиторын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Агуулга

Агуулга 0
1. Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл 1
2. Аудиторын дүгнэлт 2
3. Аудитлагдсан санхүү байдлын тайлан 3
4. Аудитлагдсан орлого үр дүнгийн тайлан 4
5. Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан 5
6. Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан 6
7. Санхүүгийн тайлангийн тодруулгууд 7
1. ЛэндМН СМЭ ББСБ-ын талаарх мэдээлэл 7
2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо 7
3. Хүүгийн болон хүүгийн бус орлого 14
4. Хүү болон хүүгийн бус зардал 14
5. Орлогын татварын зардал 14
6. Мөнгөн хөрөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 14
7. Авлага, бусад хөрөнгө 15
8. Бусад өр төлбөр 15
9. Хувьцаат капитал болон нөөц сан 15
10. Хуримтлагдсан ашиг, алдагдал 15
11. Эрсдэлийн удирдлагын тодруулга 15

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнесс оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088
Цахим хаяг: www.shonkhor.mn
И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2025.02.11 № 25/08

танай _____ -ны № _____ -т

“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчдэд

АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид **“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК**-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр **“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК** ийн 2024 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай залът үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас бүхэлдээ авгид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтаж)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэх талаар боломжит үндэслэлтэй баталгааг олж авах, түүнчлэн аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй бүхий залилан ба алдааг бүрэн илэрхийлдэг гэсэн баталгаа биш юм.

Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг.

Бусад

Энэхүү дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн ба дүгнэлтийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ Д.ШИЙРЭВ

BEDFORD
УЛААНБААТАР ХОТ
RUSSELL
INTERNATIONAL
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
MEMBER

3. АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"ЛэндМН СМЭ ББСБ" ХХК (төгрөгөөр)

Балансын зүйл	2024.12.31	2024.01.01
Хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	100,282,623.45	4,001,000,000.00
Бусад санхүүгийн хөрөнгө	4,100,000,000.00	-
Санхүүгийн хөрөнгийн дүн	**4,200,282,623.45**	**4,001,000,000.00**
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**-**	**-**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**4,200,282,623.45**	**4,001,000,000.00**
Өр төлбөр		
Бусад санхүүгийн өр төлбөр	1,217,700.00	1,000,000.00
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**1,217,700.00**	**1,000,000.00**
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**-**	**-**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**1,217,700.00**	**1,000,000.00**
Өмч		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	4,000,000,000.00	4,000,000,000.00
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	199,064,923.45	
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	**4,199,064,923.45**	**4,000,000,000.00**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	**4,200,282,623.45**	**4,001,000,000.00**

BEDFORD RUSSELL INTERNATIONAL УЛААНБААТАР ХОТ ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК 9026010111 5821975 ШЖР1208 MEMBER

SHONKHOR 01 estimate & audit

4. АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"ЛэндМН СМЭ ББСБ" ХХК (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2024.01.01
Хүүгийн орлого		
Банканд байршуулсан хөрөнгийн	221,441,137.17	-
Хүүгийн орлогын дүн	**221,441,137.17**	-
Хүүгийн зардлын дүн	-	-
Хүүгийн цэвэр орлого	**221,441,137.17**	-
Бусад орлого		
Хүүгийн бус орлого		
Бусад орлого, олз		
Бусад зардал	**232,100.00**	
Хүүгийн бус зардал	232,100.00	-
Бусад зардал, гарз		-
Татварын өмнөх ашиг, алдагдал	**221,209,037.17**	-
Орлогын татварын зардал	22,120,903.72	-
Татварын дараах ашиг, алдагдал	**199,088,133.46**	
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал		
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	**199,088,133.46**	-

BEDFORD RUSSELL INTERNATIONAL УЛААНБААТАР ХОТ ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК 9026010111 5021978 ШЖР1208 MEMBER

SHONKHOR 01 estimate & audit

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"ЛэндМН СМЭ ББСБ" ХХК **төгрөгөөр**

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
Залруулсан үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			
Бусад дэлгэрэнгүй орлого			
Өмчид гарсан оруулалт	4,000,000,000.00	199,064,923.45	4,199,064,923.45
Зарласан ногдол ашиг			-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	**4,000,000,000.00**	**199,064,923.45**	**4,199,064,923.45**



SHONKHOR 01
estimate & audit

6. АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"ЛэндМН СМЭ ББСБ" ХХК (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2024.01.01
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зээлийн хүүгийн орлого	199,297,023.45	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**199,297,023.45**	**-**
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	4,100,014,400.00	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**4,100,014,400.00**	**-**
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(3,900,717,376.55)**	**-**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан		4,000,000,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	**-**	**4,000,000,000.00**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**-**	**4,000,000,000.00**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгө гүйлгээ		
Бусад	-	1,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлог	**-**	**1,000,000.00**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарла	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	**-**	**1,000,000.00**
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(3,900,717,376.55)**	**4,001,000,000.00**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үл	**4,001,000,000.00**	**-**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн ү	**100,282,623.45**	**4,001,000,000.00**

BEDFORD RUSSELL INTERNATIONAL ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК MEMBER

SHONKHOR 01 estimate & audit

7. Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. ЛэндМН СМЭ ББСБ-ын талаарх мэдээлэл

ББСБ нь 2024 оны 04 сарын 03-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Монгол улсын бүртгэлийн албанд бүртгэгдсэн улсын бүртгэлийн 9015005204 дугаартай, регистерийн 7010697 дугаартай. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн ТЗ 101/783 дугаартай тус зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Тусгай зөвшөөрөл авсан үйл ажиллагааны төрлүүд:

- Банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа

Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж, Сувд төв, 1,2 тоот.

Дүрмийн сангийн хэмжээ: 4,000,000,000 төгрөг

Компанийн Гүйцэтгэх захирал: Ж.Сосор Харилцах утас: 88060481

Нягтлан бодогч: Г. Золжаргал Харилцах утас: 99021523

2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

Тайлан бэлтгэх үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангуудыг "Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого"-ын дагуу толилуулсанаар бэлтгэсэн.
ББСБ –ын санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчим дээр үндэслэн бэлтгэгдсэн байна. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачлан, Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.
Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай мөрдсөн болно.

Санхүүгийн хэрэглүүрүүд – Хэмжилтийн үндсэн нэр томъёо

Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас нь хамааруулан бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр дор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.
Бодит үнэ цэнэ нь ажил гүйлгээг бүртгэх өдрөөр тухайн зах зээлд оролцогчдын хоорондын арилжаагаар байнга хийгдэх хөрөнгийн худалдаа эсвэл өр төлбөрийг шилжүүлэх үнэ юм. Бодит үнэ цэнийг хамгийн сайн илэрхийлэх дүн нь тухайн идэвхтэй зах зээлийн арилжааны үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ.
Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо тухайн хөрөнгө болон өр төлбөрийн үнэ болон тухайн байгууллагын эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн тоо ширхэгээр үржүүлэн гаргана.
Гадаад зах зээлийн үнийн мэдээлэл авах боломжгүй санхүүгийн зарим хэрэгслийн бодит үнэ цэнийг хэмжихэд бэлэн мөнгөний урсгалын хөнгөлөлттэй загвар эсвэл сүүлийн үеийн гүйлгээний дүн эсвэл хөрөнгө оруулагчдын санхүүгийн мэдээллийг харгалзан үзэх зэрэг үнэлгээний аргачлалыг ашигладаг.
Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийг идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнэ) боломжит өгөгдлүүдийг ашиглан, үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү тулгаарлан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшингийн бодит үнэ цэнэ гэж тус тус ангилна.

SHONKHOR 01 estimate & audit

Өртөг гэдэг нь хөрөнгийг худалдан авах үед мөнгөөр болон бусад хэлбэрээр төлсөн төлбөрийн бодит үнэ цэнэ бөгөөд үүнд хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан ажил гүйлгээний зардлууд ч мөн багтана. Бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй эсвэл хөрөнгийн зах зээлээс үнийг нь тодорхойлох боломжгүй, өмчөөрх хөрөнгө оруулалт болон дээрхтэй адил өмчийн хэрэглүүрээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг өртгөөр нь хэмжинэ.

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал гэдэг нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх байсан зардал юм. Гүйлгээний зардалд зээл олгох, нягтлан бодох бүртгэл хөтлөх үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад, зөвлөх, хуулийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулалтын үйлчилгээний төлбөр болон банкны шимтгэл, хураамж төлбөрүүд, мөн гадаад гүйлгээ, дотоодын банк, банк санхүүгийн байгууллагад шилжүүлэх өр төлбөрийн шилжүүлэг, ХАОАТатвар, Нийгмийн даатгалын байгууллагад төлөх татвар хураамжууд хамаарна. Мөн гүйлгээний зардалд репо зээлийн өрийн хямдруулалт буюу нэмэгдэл, санхүүжилтийн зардлууд, дотоод удирдлагын буюу итгэлцлийн үйлчилгээний өглөгийн зардлууд орно.

Хорогдуулсан өртөг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн дүнгийн аливаа эргэн төлөлтийг хасан, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардал, мөн үнийн аливаа нэмэгдэл эсвэл хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүний орлого, хуримтлагдсан хүүний зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй бөгөөд тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох зүйлийн дансны үнэд оруулан тусгасан болно.

2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үлдэгдэл тооцогдох хүүний хувийг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт үүний хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүний хувь болно.

Үр ашигт хүүний хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүний зөрүүг илэрхийлсэн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм нэмэгдэл, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүний бүрэлдэхүүн хэсэг болно.

Санхүүгийн хөрөнгийн ангилал

Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. (а) зээл болон авлага; (б) худалдан борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө; (в) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө; болон (г) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийг дотор нь 2 ангилдаг: (i) анх хүлээн зөвшөөрөх үед ийнхүү ангилагдсан, (ii) худалдан борлуулах зорилгоор эзэмшихээр болсон. ББСБ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн хөрөнгө нь бүгд "зээл болон авлага" хэмээн ангилагдсан. Зээл болон авлагад ББСБ нь ойрын хугацаанд худалдан борлуулах зорилготой байгаа санхүүгийн хөрөнгүүдээс бусад тодорхойлж болохуйц эсвэл тогтмол төлбөртэй, деривативгүй, харьцуулагдахуйц бус санхүүгийн хөрөнгүүд орно

SHONKHOR 01
estimate & audit

Санхүүгийн өр төлбөрийн ангилал

ББСБ-ын бүх санхүүгийн өр төлбөрүүдийг бусад санхүүгийн өр төлбөр ангилалд ангилж, хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх

Бүх санхүүгийн хэрэглүүрүүдийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн найдвартай нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ байдаг. Бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн хооронд зөрүү үүссэн нөхцөлд л тухайн зөрүү дүнгээр анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг бүртгэх бөгөөд энэхүү бодит үнэ цэнэ нь ижил төрлийн хэрэглүүрийн саяхан арилжаалагдсан дүн болох нь эсвэл зөвхөн зах зээл дээрээс бэлэн олж болохуйц мэдээлэл дээр үндэслэж үнэлгээний аргачлалаар тооцсон болох нь нотлогдсон байх ёстой. Тухайн санхүүгийн хэрэглүүрийг зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("энгийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан хүлээлгэн өгөх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдаа, худалдан авалтын арилжаа хийсэн өдөр буюу ББСБ нь санхүүгийн хөрөнгийг хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн өдрөөр хүлээн зөвшөөрнө. Бусад бүх худалдан авалтыг ББСБ нь санхүүгийн хэрэгслийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх

ББСБ-ын санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг хүлээн авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) ББСБ нь хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл шаардлага хангасан, дамжуулан өгөх хэлцэлд оролцсоны үр дүнд (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон огоожийг үндсэнд нь шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлээгүй мөн авч үлдээгүй боловч хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Нөгөө тал нь хөрөнгийг бүхэлд нь гуравдагч этгээдэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр борлуулах бодит боломжгүй байгаа нөхцөлд хяналтыг авч үлдсэнд тооцно.

Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн өр төлбөрийн төлөх үүргийн хугацаа дууссан, санхүүгийн өр төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдсөн болон уг өр төлбөрийг төлөх үүрэг дуусгавар болсон үед санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна.

Санхүүгийн өр төлбөрийн хугацаа дуусаагүй үед тухайн өр төлбөрийн нөхцөл ихээхэн өөрчлөгдсөн үед эсвэл зээлдүүлэгчээс хуучин өр төлбөрийнхөө оронд өөр нөхцөлтэй, шинэ өр төлбөр сольж хүлээж авсан тохиолдолд өмнөх өр төлбөрийг данснаас хасч, шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд шинэ болон хуучин өр төлбөрийн дансны үнийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

"Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах" журмыг СЗХ-ны дарга болон Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг журмын дагуу олгосон зээлийг хугацаа хэтэрсэн хоногоос хамааран 5 ангилах ба ангилал тус бүрт урьдчилан тогтоосон, тогтмол хувиар үнэ цэнийн бууралтын санг тооцоолдог.

SHONKHOR 01
estimate & audit

Зээлийн үнэ цэнийн бууралтын сан тооцох хувийг доорх хүснэгтээр харуулав:

	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацаа хэтэрсэн хоног	Хугацаандаа төлөгдөж байгаа	1-90 хоног	91-180 хоног	181-360 хоног	360 хоногоос дээш
Зээлийн эрсдэлийн сангийн хувь /%/	0%	5%	25%	50%	100%

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах, хугацаагүй хадгаламжууд, банкинд 3 сар болон түүнээс бага хугацаатай байршуулсан богино хугацаат хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалтууд орно. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хязгаарлалттай дансуудыг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

Үйл ажиллагааны түрээс

ББСБ нь түрээсийн гэрээнд түрээслэгчээр оролцож, өмчлөлийн ихэнх эрсдэл болон өгөөж нь түрээслүүлэгчээс ББСБ-д шилжин ирээгүй тохиолдолд түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилж, тухайн тайлант хугацааны орлого, үр дүнгийн тайланд (түрээсийн зардлаар) бүртгэнэ. Түрээслэгч тал нь нэмэгдэл төлбөртэй болон төлбөргүйгээр хөрөнгөө үргэлжлүүлэн түрээслүүлэх эрхтэй ба түрээсийн хугацааны эхэнд тухайн эрхээ ирээдүйд хэрэгжүүлнэ гэсэн тодорхой үндэслэлтэй үед түрээсийн гэрээний нөхцлийг тухайн хугацаанд цуцлах боломжгүй байна. Хэрэв хөрөнгийг үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хуваарилан түрээсийн орлогоор бүртгэнэ.

Үндсэн хөрөнгө

ББСБ-ын эзэмшиж буй үндсэн хөрөнгүүдийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тусгана. Урсгал засвар, үйлчилгээний өртгийг гарсан үед нь зардлаар бүртгэнэ.

Үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн томоохон бүрэлдэхүүн хэсгийг шинэчилсэн бол, холбогдох өртгийг капиталжуулж, хуучин сольсон хэсгийн дансны үнийг зарлагадана. Тайлант хугацааны эцэст удирдлага үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх аливаа үзүүлэлт байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв ийм үзүүлэлт байгаа нөхцөлд хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох ба энэ хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр тодорхойлогддог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулан үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэдэг. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан тооцоолол өөрчлөгдсөн нөхцөлд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно.

Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг дансны дүнтэй харьцуулан тооцож, тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ (үйл ажиллагааны бус орлого, зардал хэсэгт).

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

SHONKHOR 01
estimate & audit

	Ашиглалтын хугацаа /жилээр/
Барилга	25 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	2 жил

Хэрэв хөрөнгө хуучирсан, ашиглалтын хугацаа нь дууссан бол хөрөнгийн үлдэх өртгийг ББСБ-ын хөрөнгийг борлуулах боломжит үнээс худалдан борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээр тооцоолно. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст хянаж, шаардлагатай гэж үзвэл өөрчилнө.

Биет бус хөрөнгө

Гүүдвилээс бусад биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд ББСБ-ын үндсэн биет бус хөрөнгө нь компьютерийн програм хангамж юм.

Худалдан авсан программ хангамжийг өртөг дээр нь тэдгээрийг ашиглахад бэлэн болгохтой холбогдон гарсан зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгүүдийг тэдгээрийн ашиглагтын хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна:

Үнэ цэнэ нь буурсан бол биет бус хөрөнгийн дансны үнийг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон түүний бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгийн аль их дүн хүртэл бууруулна.

Санхүүгийн программ хангамж

Сангийн яамны тусгай зөвшөөрөлтэй санхүүгийн программ хангамжыг ашигладаг.

Орлогын албан татвар

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэглэгдэж байсан, хэрэгжих нь тодорхой болсон хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө.

Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд үүнд зардлуудтай холбоотой ажил гүйлгээ тухайн үеийн тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагаар хүлээн зөвшөөрнө.

Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдох орлого, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн юм. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталгаажуулсан гэж тооцож татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогоос бусад зүйлд ногдуулсан албан татваруудыг үйл ажиллагааны зардал хэсэгт бүртгэдэг.

Хойшлогдсон орлогын татварыг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлагналын зорилгоор тооцогдсон бүртгэлийн үнийн түр зөрүүн дээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өглөгийг бүх татварт тооцогдох түр зөрүүн дээр хүлээн зөвшөөрнө.

Татвар тооцох түр зөрүү болон татварын алдагдлыг шилжүүлэх зорилгоор хойшлогдсон татварын хөрөнгүүд нь татвар тооцогдож болох татварын ирээдүйн орлогын боломжит хэмжээгээр бүртгэгдэнэ.

Нэмэгдсэн өртгийн албан татвар ("НӨАТ")

Монгол улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар ББСБ нь НӨАТ-с чөлөөлөгдсөн байдаг.

Бусад өглөг

Бусад өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан тооцож хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

SHONKHOR 01
estimate & audit

Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт

Хүүний орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсэхтэй ББСБ-аас төлсөн эсвэл хүлээн авсан дүн багтана. Зээл олголт бүрт ногдуулах хураамжийн орлого ч мөн үр ашигт хүүний нэг хэсэг юм.

Зээл болон бусад өрийн хэрэгслүүдийн эргэн төлөгдөх магадлал бага болсон үед тэдгээрийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэх бөгөөд түүнээс хойш өнөөгийн үнэ цэнийн өсөлтийг тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын алдагдлыг тооцоход ашигласан үр ашигт хүүгийн үндсэн дээр тооцоолж, хүүний орлогоор бүртгэдэг.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг ерөнхийдөө аккруэл суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт үзүүлэх үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн хэсэгт хуваарилж тооцдог.

Хувьцаат капитал

Эздийн оруулсан хувь хөрөнгийг хувьцаат капитал буюу эздийн өмч гэж ангилдаг. Хувь хөрөнгө оруулахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хасах дүнгээр эздийн өмчид тусгах ба нийт хүлээн авсан мөнгөнөөс татвар хассан дүн байна.

Хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах

Бүртгэсэн дүнгүүдийн хооронд нь хаах эрх зүйн үндэслэлтэй бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг худалдаж, өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөөтэй тохиолдолд л санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж, санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр тайлагнана.

Гадаад валютын хөрвүүлэлт

ББСБ-ын үйл ажиллагааны валют нь түүний үйл ажиллагаагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны валют юм. Иймд ББСБ-ын үйл ажиллагааны болон тайлагналын валют нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг (төг) байна. Мөнгөөр илэрхийлэгддэг хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөөр илэрхийлэгдэх хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар ББСБ-ын үйл ажиллагааны мөнгөн тэмдэгтрүү хөрвүүлснээс үүсэх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Ажиллагсадын зардал болон холбогдох шимтгэлүүд

Цалин хөлс болон түүнтэй холбоотой бусад зардлуудыг ББСБ-ын ажилчдын ажлаа гүйцэтгэсэн тухайн сар, жилээр нь зардлаар хүлээн зөвшөөрнө. Ээлжийн амралт зэрэг богино хугацаат хуримтлагдсан цалинтай чөлөөг ажилчид ирээдүйд цалинтай чөлөө авах эрхээ үүсгэж, ажил үүргээ гүйцэтгэсэн үед хүлээн зөвшөөрнө. Өвчний чөлөө гэх мэт богино хугацаат хуримтлагддаггүй цалинтай чөлөөний зардлыг чөлөө авсан тухайн үед нь хүлээн зөвшөөрнө.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд хуулийн дагуу засгийн газрын тэтгэврийн сан болох Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. ББСБ нь хуулиар заасан нийгмийн даатгалын шимтгэлийн сангуудад төлөх төлбөрөөс гадна өөр

SHONKHOR 01
estimate & audit

ямар нэгэн тэтгэврийн сан болон түүнтэй адил өгөөж хүртэх бусад сангуудад төлбөр төлөх хууль эрх зүйн болон үүсмэл үүрэг хүлээгээгүй болно.

Ажилчдын тэтгэмж

ББСБ нь гадаад, дотоодын их дээд сургууль, богино, урт хугацааны сургалтын төлбөрөө төлөх, санхүүгийн боломжгүй ажилчдад тусламж үйлчилгээ үзүүлдэг. Бусад мэргэжлийн сургалт, гадаад аялал, тээврийн хэрэгслийн өмчлөлийг шилжүүлэх нөхцөлтэй ажилтны тэтгэмжийг тэргүүний ажилтнуудад олгодог. Мөн эрүүл мэндийн болон гэнэтийн асуудлын улмаас цалинтай эсвэл цалингүй чөлөө авах гэр бүлийн гишүүд, ажилтны гэр бүлийн гишүүнд эдийн засгийн дэмжлэг, жилд бүх ажилчдыг эрүүл мэндийн үзлэг болон бусад тэтгэмжид хамруулахаар удирдлага шийдсэн.

Холбоотой талуудын ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт ББСБ-тай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(а) Хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан нь дараах тохиолдолд холбоотой тал гэж үзнэ. Үүнд:

• ББСБ-д дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;

• ББСБ-д томоохон нөлөөлөлтэй; эсвэл

• ББСБ-ын гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(б) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь ББСБ-ын холбоотой тал болно. Үүнд:

• Аж ахуйн нэгж болон нэг ижил компани байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).

• Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуй нэгжийнхээ хараат эсвэл хамтарсан талууд байх (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь группийн хараат эсвэл хамтарсан гишүүн байх).

• Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан талууд байх.

• Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтарсан компани болоод нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани байх.

• Аж ахуйн нэгж нь ажилчдад зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр хэрэгжүүдэг байх. Хэрвээ уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол ивээн тэтгэж буй ажил олгогч нь ББСБ-ын холбоотой тал болно.

• ББСБ-д дангаараа болон хамтарсан хяналт тогтоосон хувь хүний хянадаг болон хамтран хянадаг аж ахуйн нэгж.

• ББСБ-д дангаараа болон хамтарсан хяналт тогтоосон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл уг аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.

• Аж ахуйн нэгж эсвэл үүний нэг хэсэг болох группийн гишүүн нь ББСБ эсвэл компаний толгой компанид гол удирдах албан тушаалтай бол.

Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг харгалзахдаа зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан болно.

Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан.

SHONKHOR 01
estimate & audit

3. Хүүгийн болон хүүгийн бус орлого

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Хүүгийн орлого		
Банканд байршуулсан хөрөнгийн	221,441,137.17	

4. Хүү болон хүүгийн бус зардал

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Хүүгийн бус зардал		
Бусад зардал	232,100.00	-

5. Орлогын татварын зардал

Тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан орлогын албан татварын зардлыг дор үзүүлэв:

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	22,144,113.72	-

ББСБ нь орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлагналын зорилгоор илэрхийлсэн татварын өмнөх ашгийг татвар ногдохгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар тооцон бүртгэдэг. ББСБ нь Монгол улсын татварын хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум (2020: 6 тэрбум) төгрөг хүртэлх албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 6 тэрбум (2020: 6 тэрбум) төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар (2020: 25 хувь) орлогын албан татвар төлдөг. Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг ББСБ-д хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв:

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Татварын өмнөх ашиг (алдагдал)	221,209,037.17	-
Хуулиар заасан 10 хувиар тооцсон татварын зардал (2022: 10%)	22,144,113.72	-
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	-	-
Татварын дараах ашиг (алдагдал)	**199,064,923.45**	-

6. Мөнгөн хөрөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Бэлэн мөнгө	-	-
Голомт банк (MNT)	100,282,623.45	-

Банкны үлдэгдэл дэх бэлэн мөнгө гэдэг нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудад байршуулсан харилцах дансууд бөгөөд барьцаагүй байна.
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо байна.

SHONKHOR 01
estimate & audit

7. Авлага, бусад хөрөнгө

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Байгууллагаас авах авлага	4,100,000,000.00	-

8. Бусад өр төлбөр

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Дансны өглөг	1,217,700.00	-

9. Хувьцаат капитал болон нөөц сан

ББСБ нь СЗХ-ны банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны журмын дагуу зээлийн үйл ажиллагаа явуулдаг юм.

	Хувь нийлүүлэгч тоо	Оруулсан хувь хөрөнгө MNT
2024 оны 01-р сарын 01		
Хувьцаа гаргаснаар нэмэгдсэн	1	4,000,000,000
Хуримтлагдсан ашигаар нэмэгдүүлсэн		
2024 оны 12-р сарын 31	1	4,000,000,000
Хувьцаа эзэмшигчдийг хувиар илэрхийлбэл:		
ЛэндМН ББСБ ХК	100%	100%
	100%	**100%**

10. Хуримтлагдсан ашиг, алдагдал

	2024.12.31 MNT	2023.12.31 MNT
Тухайн үеийн ашиг/алдагдал	199,064,923.45	-
Ногдол ашиг		
Хувьцаат капиталын өсөлт		
Өмнөх үеийн ашиг/алдагдал		
Хуримтлагдсан ашиг/алдагдал	199,064,923.45	-

11. Эрсдэлийн удирдлагын тодруулга

Танилцуулга

ББСБ-ын үйл ажиллагаанд учрах үндсэн бөгөөд гол эрсдлүүдэд зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл болон үйл ажиллагааны эрсдэл багтах ба эдгээр эрсдлүүдийг ББСБ-ын Гүйцэтгэх захирал удирдан хянадаг.

Эрсдлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдлийг тогтмол тодорхойлж, хэмжиж, хянах ба ингэснээр эрсдлийг хангалттай хэмжээнд нөхөх өгөөжийг өгөх бизнесийн сегментрүү хөрөнгө оруулах, ББСБ-ын хөрөнгө оруулалтын эрсдлийг тохируулсан өгөөжийг боломжит хамгийн их хэмжээнд барих явдал юм.

Эрсдлийн удирдлагын дээрх процесс нь ББСБ-ын тогтвортой хөгжилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд ББСБ-ын салбар, нэгжийн ажилтан бүр өөр өөрсдийн ажил үүргийн хүрээн дэх эрсдэлд хариуцлагатай хандах ёстой.

SHONKHOR 01
estimate & audit

ББСБ нь эрсдлийн удирдлагын бодлоготой бөгөөд энэ бодлогоор эрсдлийг арилгахгүй ч, эрсдэл болон өгөөжийн харьцааг хамгийн ашигтай хэмжээнд барих явдал юм. Эрсдлийн удирдлагын бодлого нь доорх зүйлсийг тусгана. Үүнд:
(i) Эрсдлийг удирдах гишүүд нь эрсдлийн удирдлагын шаардлага болон түүний хэмжилтийн системийг нарийн тодорхой ойлгодог байх;
(ii) Хөрөнгийн хуваарилалтын эрсдлийг бодлоготой нийцүүлэн хийх;
(iii) ББСБ-ын үйл ажиллагааны чиглэл нь авч чадах/хүлээн зөвшөөрөх эрсдлийн хэмжээтэй уялдах

Эрсдлийн удирдлагын бүтэц
ББСБ-ын эрсдэлийн удирдлагыг одоогоор Гүйцэтгэх захирал болон Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал ерөнхийд нь хариуцан ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд Гүйцэтгэх захирал хүлээн зөвшөөрөх хэмжээний эрсдэл, эрсдлийн мэдрэмжийг тусгасан эрсдлийн бодлого болон зээлийн эрсдлийн бодлогыг баталсан. ББСБ-ын Гүйцэтгэх захирлын тушаалаар ерөнхий үйл ажиллагааны эрсдлийг хянах, бүх салбарын газар дээрх болон зайны хяналтыг хариуцах үүрэг бүхий Эрсдэл хяналт шалгалт хариуцсан захирал томилсон.

Зээлийн эрсдэл
ББСБ-ын үндсэн зээлийн эрсдэл нь одоо үзүүлж буй зээлийн үйл ажиллагаанаас үүсэх зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэл юм.
Зээлийн эрсдэл нь 1) зээлийн лимит тогтоох, батлах болон 2) зээл олголтын дараах гүйцэтгэлийг хянах гэсэн хоёр үндсэн үйл явцуудаас үүсч болно. Зээлийн лимит тогтоох, батлах үйл явцаас үүсэх зээлийн эрсдэлд тухайн харилцагчийн чадварт тохирохгүй зээлийн хэмжээ тогтоох эсвэл тохиромжгүй дүнтэй, зохисгүй хүүний түвшинтэй зээл олгох шийвэр батлах аль нь ч хамаарч болно.
Удирдлага хугацаа хэтэрсэн зээлүүдийг хугацаа хэтэрсэн хоногоор нь 1, 30, 60, 90, 90-180, 365 хоногоос дээш гэж тус тус ангилан, тэдгээрийг хугацаа хэтэрсэн зээлийн ангилал бүрд тохирох зорилтот хувьд үндэслэн хянадаг.

Ямар нэг барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалтыг харгалзахгүйгээр өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшин
Доорх хүснэгтэнд санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшинг харуулав. Барьцаа хөрөнгийн гэрээний ашиглалтын бууруулах нөлөөг үл хамааруулан өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшинг өссөн дүнгээр харуулав.

	Эрсдэлийн хамгийн өндөр түвшин	
	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Банк дахь харилцах данс	100,282,623.45	-
Олгосон зээл болон урьдчилгаа	-	-
	100,282,623.45	**-**

1. Төлбөрийн чадварын эрсдэл
ББСБ нь өөрийн өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах төлбөрүүд болон зээлийн санхүүжилтээ хангахуйц сантай байх зорилгоор төлбөрийн чадварын эрсдлээ удирддаг.

2. Зах зээлийн эрсдэл
ББСБ нь зах зээлийн эрсдлийг багцын аргаар удирддаг. Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүүний түвшин, гадаад

SHONKHOR 01 estimate & audit

валютын ханш гэх мэт зах зээлийн хувьсагчуудын өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ
цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн эрсдлийн удирдлагын зорилго нь
хүүний цэвэр орлогыг хамгийн өндөр байлгаж чадах оновчтой санхүүгийн тайлангийн бүтцийг бүрдүүлэх юм.

3. Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хувь хүний санамсаргүй болон санаатай үйлдэл болон бусад гадаад хүчин зүйлүүдийн улмаас ББСБ алдагдалд орж болох эрсдэл юм. Хяналт алдагдах үед үйл ажиллагааны эрсдэл нь нэр хүнд унах, хуулийн болон зохицуулалтын асуудалд орох, улмаар санхүүгийн алдагдалд ороход ч хүргэж болно. ББСБ хэдийгээр үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн арилгах ололцоогүй
ч хяналтын бодлого, үйлчилгээний болон арын албаны ажил үүргийг салангид байлгах, системд хяналттай нэвтрүүлэх, батлах болон тооцооо нийлэх процедурууд гүйцэтгэх, боловсон хүчний боловсрол хийгээд гүйцэтгэлийг үнэлэх зэрэг мониторинг сайжруулах замаар ББСБ энэ төрлийн эрсдэлийг удирдаж, эрсдлийг бууруулж болно.

4. Зохистой харьцааны эрсдэл

ББСБ санхүүгийн бүтэц, активын чанар, хамгаалалтын болон төлбөрийн чадварын үзүүлэлтүүдийг СЗХ-с баталсан журам болон шалгуур харьцаануудаар хянадаг. ББСБ капиталын удирдлагын үндсэн зорилт нь ББСБ өөрийн хөрөнгийн зохистой шалгууруудыг хангах, учирч болзошгүй эрсдлээс сэргийлж чадах капиталын зөв харьцааг хангаж ажиллахад оршино.
СЗХ-с баталсан журмын дагуу ББСБ нь тайлант үеийн эцэс бүрт зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай.
СЗХ-с тавьсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд ББСБ-ын удирдлагын зүгээс хяналт тавьдаг. Санхүүгийн хэлтэс ББСБ-ын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулж, үр дүнгээ удирдлагын багт танилцуулдаг ба СЗХ-д зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа илгээдэг.

5. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

Хуулийн үйл ажиллагаа

Тогтмол болон хэвийн үйл ажиллагааны явцад ББСБ-ын эсрэг нэхэмжлэлүүд ирэх магадлал бий. Удирдлага өөрсдийн үнэлэмж, тооцоо, ББСБ-ын мэргэжилтнүүдийн зөвлөмжид үндэслэн зарга, нэхэмжлэлтэй холбоотой материаллаг хохирол хүлээхгүй гэж үзэж байгаа тул санхүүгийн тайланд үүнтэй холбогдуулж аливаа сан хүлээн зөвшөөрөөгүй.

6. Татварын хууль, зохицуулалт

ББСБ-ын удирдлага холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
Удирдлага одоогоор татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдлийг бага гэж дүгнэж байгаа бөгөөд татварын эрсдлийг цаашид тогтмол үнэлэх бөгөөд дээрх дүгнэлт нь одоогоор урьдчилан мэдэгдэх боломжгүй ирээдүйн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж магадгүй гэж үзэж байна.

Түрээсийн гэрээгээр хүлээсэн үүрэг

ББСБ нь сар сардаа төлөх төлбөрийн түрээсийн гэрээ байгуулсан байна.

7. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт

Бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга болон үнэлэмжүүд

Бодит үнэ цэнийг нягтлан бодох бүртглийн гол бодлогуудын товчоонд заасан 3 түвшинд хэмжинэ.

SHONKHOR 01
estimate & audit

Удирдлага санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн түвшингээр нь ангилахдаа өөрсдийн үнэлэмжийг ашиглана. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход тохируулга ихээхэн хийгдэх өгөгдлийг ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хамаарна. Ашиглаж буй өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн хэмжилттэй бүхлээр нь харьцуулан авч үзнэ. Харьцуулж болох санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн ханш нь ихэнхдээ эхлэлийн үеийн зах зээлийн ханштай ижил байдгаас шалтгаалан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнэтэй ойролцоо байдаг.

8. Холбоотой талуудын ажил гүйлгээ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний үлдэгдлийг доор харуулав:

	2024.12.31	2023.12.31
	MNT	MNT
Холбоотой талуудын авлага	4,000,000,000	-

SHONKHOR 01
estimate & audit